

БРАЗИЛ: МАРИЭЛЬ ФРАНКО

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ



ШУДАРГА ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙН ТӨЛӨӨ ТЭМЦСЭН

Мариэль Франко илүү шударга, бас аюулгүй Рио де Жанейрогийн төлөө чин зоригтойгоор тэмцсэн. Ядуусын хороололд бага насаа өнгөрөөсөн, олонд танигдсан хотын зөвлөлийн гишүүн байсан бөгөөд үргэлж өнгөт арьст эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс болон залуучуудын төлөө тэмцэж байсан. “Мариэль бол эрхийн төлөө тэмцэх гэж төрсөн” хэмээн хамтрагч Моника нь өгүүлсэн юм. Цагдаа нар түүнийг хүн алсан хэрэгт буруутгаж байжээ.

Гэвч 2018 оны 3-р сарын 14-нд Мариэль жолооч Андерсон Педро Гоместай хамт машиндаа буудуулж нас барсан байв. Энэ хүн амины гэмт хэргийг мэргэжлийн хүн үйлдсэнийг тогтоосон бөгөөд шинжээчид бууны сум Бразилийн Холбооны Цагдаагийн

газарт харьяалагддаг болохыг хэлсэн байна.

Бразил бол Мариэль шиг хүний эрх хамгаалагчдын хувьд хамгийн аюултай улсуудын нэг бөгөөд 2017 онд дор хаяж 70 хүн амиа алдсан байна. Ихэнх хэргийг мөрдөн шалгадаггүй ба хэрэгтэн хариуцлага хүлээдэггүй, сул чөлөөтэй явж байдаг. Хүний эрх хамгаалагчид байнгын айдас дунд амьдарч байна.

Хамтдаа шударга ёсыг тогтоох хүртлээ бид зогсохгүй гэдгээ Бразилын эрх баригчдад харуулцаага. Тэд хүний эрх хамгаалагчдыг халдлагаас хамгаалах ёстой. Эрх баригчид Мариэлийг алсан хэрэгтнийг шийтгэх ёстой. Түүний эгч Аниелла “Бид бүх хүч чадлаараа шударга ёсыг шаардах болно” хэмээн өгүүлсэн юм.



Мариэлийн төлөө шударга ёсыг шаардан Бразилын Ерөнхийлөгчид хандан захидал бичнэ үү.

Brazilian President
Praça dos Três Poderes, Palácio do Planalto - Brasília (DF)
CEP 70150-900, Brazil
Email: gabinetepeessoal@presidencia.gov.br
Twitter: @planalto
Salutation: Dear President



Мариэлийн гэр бүлийнхэнд эв санааны нэгдлээ илэрхийлээрэй.

Amnesty International Brazil
Rua da Glória, 344 (3rd floor) Glória
CEP 20241180 Rio de Janeiro (RJ)
Brazil